



2017

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ХУРААНГУЙ

“ТӨВ БАНКНЫ АЛДАГДАЛ, ӨӨРИЙН ХӨРӨНГӨ”

СЭДЭВТ ӨГЛӨӨНИЙ ЦАЙН УУЛЗАЛТЫН ХУРААНГУЙ

| 2017 ОНЫ 12-Р САРЫН 05-НЫ ӨДӨР





TISHIN TOWER

АГУУЛГА

1-р хэсэг: “Төв банкны алдагдал, өөрийн хөрөнгө” сэдэвт өглөөний цайн уулзалтын тайлан	4
<i>Төв банкны алдагдал: бусад улсын туршлага, шалтгаан, бодлогын санал</i>	4
<i>Төв банкны алдагдлыг бууруулах стратеги, хэрэгжүүлэх арга хэмжээ</i>	5
<i>Төв банкны өөрийн хөрөнгө ба алдагдалын талаарх хуулийн зохицуулалт</i>	6
2-р хэсэг: Уулзалтад оролцогчдын санал	7
3-р хэсэг: Уулзалтад оролцогчдын тавьж буй нийтлэг асуудал	9



“Төв банкны алдагдал, өөрийн хөрөнгө” сэдэвт өглөөний цайн уулзалтын тайлан

ТӨВ БАНКНЫ АЛДАГДАЛ: БУСАД УЛСЫН ТУРШЛАГА, ШАЛТГААН, БОДЛОГЫН САНАЛ

Төв банкны алдагдал нь Төв банкны хараат бус байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Монголбанкны алдагдалд нөлөөлсөн хүчин зүйлс:

- Төсвийн шинжтэй үйл ажиллагаа (*Засгийн газар болон хувийн секторт зориулсан хямд хүүтэй эх үүсвэр, шатахууны үнийг тогтворжуулахад чиглэсэн валютын хэлцэл*);
- Ханшийн тогтвортой байдлыг зорьсон валютын захирах интервенц, ханшийн уян хатан бус байдал;
- Төсөв, мөнгөний хэт тэлсэн бодлого;
- Гадаад зээл;
- Дериватив хэрэгсэл;
- ТБҮЦ-ны хүү /харьцангуй бага/ зэрэг юм.

Олон улсын туршлагаар Төв банкууд алдагдлаа хаахдаа тусгай санд хуримтлагдсан хөрөнгийг ашиглах, нөөц сангаас санхүүжүүлэх эсвэл дээрх төрлийн сангуудыг ашиглах бөгөөд боломжгүй тохиолдолд Засгийн газраас Төв банкны алдагдлыг санхүүжүүлдэг.

Монголбанкны алдагдлыг нэмэгдүүлэхгүй байх, одоогийн хуримтлагдсан алдагдлыг цаашид тогтвортой бууруулахын тулд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

1. Төсвийн шинжтэй үйл ажиллагаанаас татгалзах;
2. Ашиг, алдагдлыг хуваарилах механизмыг тодорхой болгох;
3. Хүүний коридорын механизмыг боловсронгуй болгох;
4. Гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх;
5. Төв банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх замаар алдагдлын сөрөг нөлөөг арилгах.



Монголбанкны алдагдлыг бууруулахын тулд

- 1. Төсвийн шинжтэй үйл ажиллагаанаас татгалзах;**
- 2. Гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх шаардлагатай.**

“Төв банкны алдагдал, өөрийн хөрөнгө” сэдэвт өглөөний цайн уулзалтын тайлан

ТӨВ БАНКНЫ АЛДАГДЛЫГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ



Урт хугацааны алдагдал нь төв банкны бие даасан, хараат бус байдал, олон нийтийн төв банкинд итгэх итгэлд сөргөөр нөлөөлж, мөнгөний бодлогын үр нөлөөг бууруулдаг байна.

Төв банкны үйл ажиллагаа, бодлого хэрэгжүүлэх арга хэрэгсэл нь ердийн нөхцөлд буюу зах зээлийн зарчмаар хэрэгжиж буй үед ашигтай байх боломжтой бөгөөд эдийн засгийн хямрал зэрэг онцгой нөхцөлүүдэд бусад салбарын зардлыг өөртөө хүлээх нь алдагдал бий болох үдсэн шалтгаан болдог. Тиймээс төв банкны аливаа бодит алдагдал нь **төсвийн шинжтэй зарлага** гэж ойлгогдож болно. Төв банк нь Засгийн газар, арилжааны банкууд, гадаадын харилцагч банкууд гэсэн үндсэн гурван харилцагчтай бөгөөд төв банкны үйл ажиллагааны ашиг/алдагдал нь мөн адил дүнгээр харилцагч талуудад тусдаг. Төв банкны бие даасан хараат бус байдлыг энэ гурван харилцагч талуудын ашиг төв банкны алдагдалтай хэрхэн хамаарал/корреляцтай байгаагаар хэмжиж болно. Тэгэхээр төв банкны бие даасан хараат бус байдлыг хадгалах нь санхүүгийн хувьд бие даасан хараат бус байдлыг хадгалахыг хэлж байна.

Өнөөгийн байдлаарх Монголбанкны хуримтлагдсан алдагдал нь өнгөрсөн хугацааны эдийн засгийн харилцааны үзүүлэлт бөгөөд цаашид төв банкны санхүүгийн бүтцийг зөв болгох замаар өөрийн дархлааг сайжруулах шаардлагатай.

Төв банкныг алдагдалгүй ажиллуулах санал:

1. Төсвийн шинжтэй үйл ажиллагаанаас татгалзах;
2. ТБҮЦ-наас аажмаар татгалзах, хүүний коридорыг нэвтрүүлж, хүүг бууруулах;
3. Интервенцээс аажмаар татгалзаж, гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх.

“Төв банкны алдагдал, өөрийн хөрөнгө” сэдэвт өглөөний цайн уулзалтын тайлан

ТӨВ БАНКНЫ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ БА АЛДАГДАЛЫН ТАЛААРХ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Төв банк бол **Төрөөс үүсгэн байгуулсан хуулийн этгээд** бөгөөд Хуулийн этгээдийн хууль зүйн тодорхойлолт:

“Иргэний хуулийн 25.1. Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ.” Төв банкны хуулиар Монголбанк үйл ажиллагаа явуулахад хүлээх үүргийн баталгаа болох зорилгоор өөрийн хөрөнгөтэй байна гэж заасан. Иймд хуулийн этгээд тул өөрийн хөрөнгөтэй байх хууль зүйн үндэслэл баталгаажсан байдаг. Төв банкны өөрийн хөрөнгө, түүний бие даасан, хараат бус байдлыг мөн адил илэрхийлдэг.

Олон улсын жишиг: Өөрийн хөрөнгийн дутагдлыг Төв банкны шаардсаны дагуу нөхдөг зохицуулалттай.

Монголбанкны жилийн санхүүгийн тайлангаар өр төлбөр болон хувь нийлүүлсэн хөрөнгийн нийлбэр нь активаас хэтэрсэн тохиолдолд дараах арга хэмжээ авна:

1. Санхүүгийн тайлан гарснаас хойш 30 хоногийн дотор зөрүү үүссэн нөхцөл байдлыг үнэлж, түүний хэмжээ, үүссэн шалтгаан, нөхцөлийг тусгасан тайланг Монголбанкны Удирдах зөвлөл хэлэлцэнэ.
2. Удирдах зөвлөл уг тайланг баталсан бол Монголбанк нь хувь нийлүүлсэн хөрөнгийг хуульд заасан хэмжээнд хүргэх зорилгоор Засгийн газраас өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлнэ.
3. Хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Засгийн газраас шаардлагатай хэмжээгээр мөнгөн хөрөнгөөр эсвэл тухайн үеийн зах зээлийн хүүгээр тооцсон тодорхой хугацаатай өөрийн хэрэгслийг гаргаж Монголбанкинд шилжүүлэх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэнэ.”


Төв банк бол төрөөс үүсгэн байгуулсан хуулийн этгээд юм.

Өөрийн хөрөнгийн дутагдлыг Төв банкны шаардлагын дагуу төрөөс нөхдөг зохицуулалт олон улсын жишигт бий.

Уулзалтад оролцогчдын санал



С.Ариунаа



Д.Түвшинжаргал

С.Ариунаа

*Эдийн засгийн ухааны
профессор*

Монгол Улсын Их сургууль

Д.Түвшинжаргал

Ахлах багш

Санхүү, эдийн засгийн
их сургууль

- Монголбанкны дүрмийн сангийн хэмжээ 5 тэрбум төгрөг байдаг, энэ хэмжээг нэмэгдүүлэх саналтай байгаа юм байна. Харин олон улсын туршлагаар төрийн болон хувийн өмчит төв банкны дүрмийн сангийн хэмжээний талаар судалж үзвэл зохимжтой.
- Сүүлийн жилүүдэд төв банк төсвийн шинжтэй олон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн. Мөн цаашид багш, эмч нарын цалинг нэмэх зэрэг нийгмийн асуудлыг шийдэхтэй холбоотойгоор төсвийн шинжтэй зардлыг бууруулахад хүндрэлтэй байх талтай.
- Сүүлийн жилүүдэд төсвийн тогтвортой байдлын хуулиас гадуур Засгийн газар, Монголбанк эдийн засагт маш их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн. Төсвийн нэгдмэл бус байдлаас шалтгаалж бодит эдийн засагт олон сөрөг нөлөөг үзүүлсэн. Харин байгалийн баялгаас хамааралтай Чили, Норвеги, Малайз, Перу зэрэг орнуудыг авч үзэхэд эдгээр улсууд төсвийн дүрмийг мөрддөг.
- Сүүлийн жилүүдэд санхүүгийн нөөц хангалттай байгаагүйн улмаас эдийн засагт шокууд хүчтэй нөлөө үзүүлсэн. Мөн ханшийг хэт уян хатан бус удаан тогтвортой байлгаснаас эдийн засгийг улам эмзэг болгосон. Хэрэв ханшийг эрт сулруулсан бол эдийн засаг зардал багатай тохируулгыг хийх байсан.
- Эдийн засгийн энэ удаагийн хүндрэл нь төв банкны хараат бус байдал ямар муу байсныг харууллаа.
- Ханшийн уян хатан байдлыг хангахдаа стратегийн хувьд аядуу байх хэрэгтэй.
- Төв банк нь эдийн засгийн тогтвортой байдлыг хангах үүрэгтэй төрөөс байгуулдаг институци юм.

Уулзалтад оролцогчдын санал



- 1990-ээд оноос төв банк урт хугацааны эдийн засгийн тогтвортой байдлыг хангахын тулд улс төрөөс хараат бус байна гэсэн ойлголт гарч ирсэн. 2000 оноос хойш эдийн засагт гарсан өөрчлөлтийг харахад Монгол улсын хувьд төв банкны хараат бус байдал харьцангуй бага байна. Гэвч дунд хугацаанд төв банкны хараат бус байдлыг нэмэгдүүлэх шаардлагатай.
- Олон нийтэд төв банк Мөнгөний бодлогын чиг үүргийн талаар танилцуулж, ойлголт өгч байгаа. Бүр цаашилбал жижиг дунд аж ахуй нэгжүүдэд төв банк эдийн засагт гүйцэтгэх үүрэг, Мөнгөний бодлогын чиг үүргийн талаар ойлголт өгвөл зохимжтой.
- Ханшийн алдагдлыг төв банк үүрч байгаа, энэ алдагдлыг бууруулах шаардлагатай ч ханшийг хэт уян хатан болгож, огцом өөрчлөлтийг хийх нь эрсдэлтэй. Мөн зарим улс орнууд алгуур шилжилтийг хийсэн байдаг. Тухайлбал, Чили улс анх ханшийг тодорхой коридорт барьж байсан ч эдийн засгийн өөрчлөлтийг дагаж ханшийн савалгаа нэмэгдэж, эдийн засагт эргэлзээ үүсэхэд инфляцийг онилох бодлого хэрэгжүүлж, ханшийн коридороо нэмэгдүүлсэн. Энэ нь хувийн секторын хэджинг санг нэмэгдүүлж, ханштай холбоотой төв банкны эрсдэлийг хувийн секторт шилжүүлсэн байдаг.

П.Баянсан

Багш

Монгол Улсын Их сургууль

Г.Рагчаасүрэн

Захирал

Гэрэгэ Партнерс

Уулзалтад оролцогчдоос тавьж буй нийтлэг асуудал



**Нийгмийн
асуудлыг
шийдэхтэй
холбоотойгоор
төсвийн
шинжтэй
зардлыг
бууруулахад
хүндрэлтэй
байх талтай.**

- Олон улсын туршлагаар төрийн өмчит төв банк болон хувийн өмчит төв банкны дүрмийн сангийн хэмжээний талаар судалж үзвэл зохимжтой.
- Нийгмийн асуудлыг шийдэхтэй холбоотойгоор төсвийн шинжтэй зардлыг бууруулахад хүндрэлтэй байх талтай.
- Төсвийн нэгдмэл байдал (төсвийн дүрмийг мөрдөх) Монголд чухал байна.
- Ханшийн алдагдлыг төв банк үүрч байгаа, энэ алдагдлыг бууруулах шаардлагатай ч ханшийг хэт уян хатан болгож, огцом өөрчлөлтийг хийх нь эрсдэлтэй.
- Олон нийтэд төв банк Мөнгөний бодлогын чиг үүргийн талаар танилцуулж, ойлголт өгч байгаа бөгөөд цаашдаа жижиг дунд аж ахуй нэгжүүдэд төв банкны эдийн засагт гүйцэтгэх үүрэг, Мөнгөний бодлогын чиг үүргийн талаар ойлголт өгвөл зохимжтой.

“ТӨВ БАНКНЫ АЛДАГДАЛ, ӨӨРИЙН ХӨРӨНГӨ”

СЭДЭВТ ӨГЛӨӨНИЙ ЦАЙН УУЛЗАЛТЫН ХУРААНГУЙ

| 2017 ОНЫ 12-Р САРЫН 05-НЫ ӨДӨР

